

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэндсүрэн	Дугаар	Л341
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Адаацаг сум
Төрсөн газар	Адаацаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шинэ шавийн жас	Сүм хийдийн дугаар	ДУАЦ 031
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Энхбаяр



Дундговь аймгийн Адаацаг сумын Шинэ шавийн жас

Энхбаяр: За та Шинэ шавийн жас дээр очиж байв уу, багадаа?

Цэндсүрэн: Очиж байсан.

Энхбаяр: Хэдэн дугантай жас байсан бэ?

Цэндсүрэн: Гурван дугантай байсан. Гурван дуган л лав байсан.

Энхбаяр: Ямар дуганууд байсан, модон дуган уу, тоосгон дуган уу?

Цэндсүрэн: Модон дуган л байсан.

Энхбаяр: Хэдэн жастай байсан бэ?

Цэндсүрэн: Дөрөв, таван жас л лав байсан байх.

Энхбаяр: Хэдэн ламтай байсан юм бол?

Цэндсүрэн: Олон ламтай байсан байх.

Энхбаяр: Багцаагаар?

Цэндсүрэн: За байзаарай, нэлээн л хэдэн лам байсан. Хурал хурдаг, ном юугаа заалгасан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчлсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энхбаяр: Суварганууд байсан уу?

Цэндсүрэн: Байсан, баруун хойд талд нь нэг их том чулуун суварга байсан. Хавтгай чулуун дээр сийлсэн суварганы зураг байсан. Одоо тэр хагараад уначихсан суварганы зурагтай чулууны хэлтэрхийнүүд одоо ч байж л байдаг.

Энхбаяр: Цам гардаг байсан уу? Хэр олон цам гардаг байсан?

Цэндсүрэн: Одоо мэдэхгүй ээ, их олон л баг бүжиглэдэг байсан. Бас майдар залаад л.

Энхбаяр: Хятадууд байсан уу?

Цэндсүрэн: Өө хятадууд цөөхөн байсан, тэр тоосго шатаадаг хятадууд цөөхөн байсан. Хөх тоосго гаргадаг.

Энхбаяр: Таныг бага байхад хийдийнх нь хамба ловон лам ч гэдэг юм уу, хэн гэдэг хүн байсан бэ?

Цэндсүрэн: Ловон лам нь манай аавын багш байсан Содномдорж гэдэг хүн байсан.

Энхбаяр: Зоч лам байсан уу?

Цэндсүрэн: Байсан, зоч багш гэж их зоч хүн байлаа. Дэндэв өвгөн гэж нэг сүрхий зоч хүн байлаа. Бас нэг том хүн чинь хэн билээ, Цэвээндорж гуай гэж нэг сүрхий зоч байсан. Тэр Дэндэв гэдэг хүн саяхан байж байгаад ерэн хэдэн онд бурхан болсон.

Энхбаяр: Ямар ямар уул овоог тахидаг байв?

Цэндсүрэн: Яг энэ хойно байгаа Эрдэнэ овоог тахина. Ондоо Хонгорын овоо, хойно нь байгаа. Наадах Тойн уулыг тахина.

Энхбаяр: Булаг шанд байсан уу?

Цэндсүрэн: Булаг шанд байхгүй. Лам нарын уудаг жасын үс гэж худгаг баруун өмнө нь байсан. Бас хойно нь Шинэ үс гэж бий.

Энхбаяр: Энэ Шинэ шавийн жасыг анх хэдэн онд байгуулагдсаныг та мэдэх үү?

Цэндсүрэн: За тэр чинь Шавийнхан гэдэг чинь нэлээн эртнийх байх аа. За Өндөр Даваа гуай гэж лам хүн байлаа. Жамба гуай, Чүлэм гуай, Лувсанбалдан гуай, Хад гуай Шардорж гээд мундаг мундаг лам хүмүүс байлаа, манай эндхийн хүмүүс. Бас холоос лам нар ирж суудаг байсан ч байж. Дашдаваа гуай гэж нэг зоч лам байсан юм. Дорж гуай одоо аймаг дээр байдаг. Одоо 94, 95 хүрч байгаа байх. Би ч одоо нүд юм хардаг бол энд нь ийм юм байсан, тэнд тийм байсан гэж та нарт заагаад өгмөөр байна. Даанч одоо юм үзэхээ байсан.

Энэ үеэр Цэндсүрэн гуайн охин ярианд оролцож / одоо дөч орчим насны / Бид нарыг бага байхад 1985, 1986 оны үед энэ Шинэ шавийн жасын суурин дээр их л гоё байшингууд байдаг байсан юм. Одоо боддоход дуганууд нь юм шиг байна лээ. Хөгшчүүл энэ тийм дуган, энэ тийм дуган гэж ярьдаг. Хүрдний хоёр байшин гээд үүдэнд нь ниижиг хоёр хөөрхөн байшин байдаг байсан. Бид нар их тоглоно. Тэгээд 1986 оны үед санагдаж байна, нэг зун манай үүгээр Оросын нэг их цэргийн цуваа явсан юм. Тэгээд нэг их том юу билээ, за байз...Тийм танж гэдэг танкаар тэр байшингуудыг бүгдийг нь дайраад нураагаад газартай тэгшилчихсэн юм. Тэгээд Орос цэргүүд бас өөрсдөө ухаад л, нутгийн хүмүүс очоод л байсан. Нэг их улаан тоос босчихсон. Тэгээд л бид нар очиход манай ажаагийн одоо энэ цоооор авдар шиг том авдраар дүүрэн судар ном, бурхан тахил ил гарчихсан, салхинд

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчлсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хийсээд л байсан санагддаг юм. Тэгээд л манай адай энэ тэр хэдэн хөгшчүүл очиж сахиус бурхнаа зарим ном судартай нь авч гэртээ авчирч нүүчихээд, тэгээд үе үе шөнө нөгөөдүүлээ гаргаж хэдэн хөгшчүүл цуглаад л хурдаг байсан юм. Ихэнх ном судар нь салхинд хийсээд л хүмүүс авч гал түлээд л байхгүй болсон.

Энхбаяр: Тэр Чойрын хийдийн цаад талд Өвөр Зүлэгтэйн хавьцаа нэг хийд байсан байх юм, тэр талаар та мэдэх үү?

Жужа: Цоржийн хийд гээд?

Цэндсүрэн: Чойрын хийдээс зүүн урагш малд явж байхад нэг хийдийн түүрх байдаг байсан. Түүнийг л хүмүүс Цоржийн хийд байсан газар гэж ярьдаг. Өөр юм мэдэхгүй.

Жужа: Энэ Шинэ шавийн түүрин дээрх суваргыг хэзээ ямар хүмүүс босгосон юм бэ?

Цэндсүрэнгийн охин: Энгийг 1993 онд манай тэр таалал болсон багшийн / Лувсанбалдан / хүүхдүүд босгосон юм. Одоо хоёр хүүхэд нь аймагт, нэг хүүхэд нь хотод байгаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчлсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон